



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2019 оны 09 сарын 17 өдөр

Дугаар 15


Улаанбаатар хот

Дизель генератор суурилуулахад  
шаардлагатай бэлтгэл ажлыг хангах тухай

Монгол улсын засгийн газрын тухай хуулийн 24-р зүйлийн 1.6 дахь заалт, Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах Монгол улсын засгийн газрын 2010 дугаар тогтоол, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/500 тоот тушаал, Эрүүл мэндийн яамны удирдлагын зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ДААЛГАХ НЬ:

1. Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/500 тоот "Тоног төхөөрөмж хуваарилах тухай" тушаалын дагуу нийлүүлэгдсэн дизель генераторыг суурилуулахад шаардлагатай стандартын шаардлага хангасан байр бэлтгэх, эмнэлгийн цахилгааны шугамд холболт хийхэд шаардлагатай кабель утсыг бэлтгэх, хэвийн ажиллагааг шалган, суурилуулан ажиллуулахад бэлтгэх, бэлэн байдлыг хангах ажлуудыг 2019 оны 10 дугаар сарын 15-ны дотор гүйцэтгэж тайланг 2019 оны 10 дугаар сарын 17-ны дотор Эрүүл мэндийн цахим мэдээллийн хэлтэст ирүүлэхийг хавсралтад заасан байгууллагуудын удирдлагуудад;
2. Халдварт өвчин судлалын үндэсний төв, Хүүхдийн төв сувилал, Зоонозын өвчин судлалын төвийн дизель генераторын холболтын зардлыг Сангийн сайдын 2017 оны 216 тоот тушаалын хавсралтад тусгасан 7.3.3 дахь хэсгийг үндэслэж хагас жилийн давсан орлогоос шийдвэрлэхийг тус байгууллагуудын удирдлагуудад даалгасугай.
3. Заасан хугацаанд ажлыг гүйцэтгээгүй тохиолдолд хариуцлага тооцохыг үүгээр мэдэгдэж байна.
4. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар /Я.Амаржаргал/-т даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

000042

Эрүүл мэндийн сайдын 2019 оны  
09 сарын 17-өдрийн 15 дугаар албан  
даалгаврын хавсралт

Дизель генераторын суурилуулалт хийгдээгүй эрүүл мэндийн  
байгууллагууд

| № | Нэр  | Тайлбар   |
|---|--|---|
| 1 | Улсын 1-р төв эмнэлэг                          | Эмнэлэгийн зүгээс бэлдэх генераторын холболтын кабель дуутуу, генераторын байранд 220В тэжээл бэлдэх шаардлагатай. Агааржуулалтын цонх болон яндан нүх гаргах шаардлагатай. Генераторын байр бэлэн болоогүй.  |
| 2 | Халдварт өвчин судлалын үндэсний төв           | Эмнэлэгийн зүгээс бэлдэх генераторын байр байхгүй. Генератор хадгалалтанд байгаа. Дэд бүтэц шийдэгдээгүй./Албан даалгаварын 2-т зааснаар шийдвэрлэх/  |
| 3 | Зоонозын өвчин судлалын үндэсний төв           | Эмнэлэгийн зүгээс бэлдэх генераторын холболтын кабель дуутуу, генераторын байранд 220В тэжээл бэлдэх шаардлагатай. Агааржуулалтын цонх болон яндан нүх гаргах шаардлагатай. Генераторын байр бэлэн болоогүй./Албан даалгаварын 2-т зааснаар шийдвэрлэх/                                 |
| 4 | Хүүхдийн төв сувилагч                          | Эмнэлэгийн зүгээс бэлдэх генераторын холболтын кабель дуутуу, генераторын байранд 220В тэжээл бэлдэх шаардлагатай. Агааржуулалтын цонх болон яндан нүх гаргах шаардлагатай. Генераторын байр бэлэн болоогүй./Албан даалгаварын 2-т зааснаар шийдвэрлэх/                                 |
| 5 | Эрүүл мэндийн хөгжлийн төв                     | Эмнэлэгийн зүгээс бэлдэх генераторын холболтын кабель дуутуу, генераторын байранд 220В тэжээл бэлдэх шаардлагатай. Агааржуулалтын цонх болон яндан нүх гаргах шаардлагатай. Генераторын байр стандарт бус өвчин хүйтэн байх магадлалтай. Генераторт өвлийн цагт гэмтэл гарах эрсдэлтэй. |
| 6 | Цус сэлбэлт судлалын үндэсний төв              | Эмнэлэгийн зүгээс бэлдэх генераторын холболтын кабель дуутуу, генераторын байранд 220В тэжээл бэлдэх шаардлагатай. Агааржуулалтын цонх болон яндан нүх гаргах шаардлагатай. Генераторын байр стандарт бус өвчин хүйтэн байх магадлалтай. Генераторт өвлийн цагт гэмтэл гарах эрсдэлтэй. |
| 7 | Орхон аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төв | Эмнэлэгийн зүгээс бэлдэх генераторын холболтын кабель дуутуу, генераторын байранд 220В тэжээл бэлдэх шаардлагатай. Генераторын байр стандартын дагуу баригдсан жишиг барилга. Генератор хүлээлгэж өгсөнөөс хойш акумулятор алга болсон.   |